

ХАЛХЫН ТОЛГОЙ БАЯНЫ НЭГ СҮРЭН ГАВЬЖ

Ж.Болдбаатар- МУИС.Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль
Ц.Пүрэвсүрэн- Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн

Өгүүлэлийн товч утга: XX зууны эхэн үеийн Монголын язгуур угсаагүй шинэ баячуудын нэг П.Сүрэнгийн аж ахуйгаа хөтлөх арга ухаан, бэл бэнчин, хүний мөс чанарын тухай өгүүлнэ.

Түлхүүр үг: Шинэ баян, аж ахуйгаа хөтлөх арга ухаан, таваарлаг аж ахуй, газар тариалан, худалдаа, жин тээвэр, бэл бэнчин

XIX зууны сүүлч XX зууны эхээр Монгол орон дэлхийн зах зээлийн хүрээнд татагдан оржээ. Олон мянган толгой малтай язгууртан хүмүүсээс гадна шинэ баячууд төрөн гарах болов. Жибзундамба хутагт 100 шахам мянга, Эрдэнэ бандид хутагт 65 мянга, ван Доржпалам 135 мянга, ван Доржцэрэн 17 мянга гаруй толгой мал үе улиран өмчилж, олон хамжлага, шавь нараараа маллуулж байжээ. (1.21) Яг энэ үед язгуур угсаагүй, 18-20 мянган толгой малтай баян малчид 30 гаруй төрсөн байна. (2.289) Уламжлалт баян язгууртан ноёд шинэ төрж буй харилцаанд татагдан орж, олз ашиг хайхын зэрэгцээ язгуур угсаагүй баячууд хөрөнгө чинээгээ өсгөхийн тулд овсгоо самбаа гаргах болов. Тэдний нэг нь Түшээт хан аймгийн Дайчин вангийн хошууны Пунцагийн Сүрэн (Сүрэнжав) юм.

1. Аж ахуйгаа хөтлөх арга ухаан

Сайхь баяны аж ахуйн гол нь **таван хошуу мал** байсан. 1918 оны тооллогын материалаас үзэхэд Сүрэн гавж адуу 2078, үхэр 2599, хонь 14974, тэмээ 18, бүгд 19669 толгой малтай байжээ. (3) Мөн энэ үед нийт мал сүргийнхээ 12.2 хувь буюу үхэр 271, адуу 848, хонь, ямаа 1268, тэмээ 18-ыг өөрийнхөө хотонд байлгаж байжээ. Бусад малыг нь ядуу, дунд чинээний хөрөнгөтэй 152 өрхийн 700 гаруй хүн адуулж маллаж байв.

Сайхь баяны хамгийн таваарлаг аж ахуй бол үхэр сүрэг байв. Түүний удам угсаа олон үхэртэй болж, хэрхэн баяжсан тухай нутгийн олон түмэн нэгэн домог ярьдаг. Эдүгээгийн Булган аймгийн Сайхан сумын нутаг дахь Өрөмийн цагаан нуурт байдаг, хөх бух Галуут, Бөөрөлжүүтийн голд ирж тэдний үнээг хээлтүүлснээс үхэр сүрэг нь их үржсэн. Тэр бухыг үхэхэд ширээр нь тулам хийж, алт, мөнгө, эрдэнэсээ түүнд хийж хадгалдаг байснаас баяжсан гэдэг. Ер нь Дайчин вангийн хошуу бол ойт хээрийн бүсэд хамрагдах учир үхэр үржүүлэхэд хамгийн тохиромжтой нутаг. Сүрэн

гавьж Вангийн хүрээний ойр орчимд өөрийн үхэр сүргээ хариулдаг айлуудаас сүү, өрөм, бяслаг, ааруул, хурууд зэргийг шинээр нь авч, зах дээр борлуулахаас гадна алс хол нутаглаж буй айлуудаас хонины гүзээнд шар, цагаан тос хураалгаж, өвлийн цагт хол, ойрын зээл дээр гаргах бэлтгэлээ базааж байв. Шар үхэрийг уналга эдэлгээнд сургана. Үхэр арвин их мах өгөх учир өвлийн идэш бэлтгэнэ. Сүүлийн үед Хиагт болон буриадаас сайн үүлдрийн бух авчирч үнээгээ хээлтүүлж байжээ. 1914 онд Вангийн хүрээнд үхрийн тарилга хийхэд Сүрэн гавьж хамгийн түрүүнд үхрээ тарилгад хамруулж байсан аж.

Сүрэн гавьжийнх адуугаа их төлөв өөрийн хотонд юмуу, хараандаа байлгаж, сүү саалийг ашиглан, уналга эдэлгээнд сургаж байжээ. Тэрбээр мал сүргээ хариулдаг айлуудад уналга эдэлгээний морь өгч, тодорхой хугацаанд сэлгэнэ. Баян сүрэгчин байсан хүмүүстэй уулзаж ярилцахад унаагаар хангалттай залгуулдаг байсан хэмээдэг. Зуны цагт хүрээ хийдийн орчим гүү барьж, айраг эсгэнэ. Бага сага айраг худалдана. Ялангуяа гавьжийн дамжаа баригсад, сүм хийдийн жас болон хувь хүн өвлийн айргаа нөөцлөх үедээ Сүрэн гавьжаас их хэмжээгээр худалдаж авч байжээ. Адуучид нь Сүрэн гавьжийн нэр дээр морь уяна. Хошууны болон овоо тахилгын наадмын олон түрүү, айргийг сайхь баяны морьд авч байжээ. Адуугаа Зад, Барт зэрэг газар оторлоно.

Сүрэн гавьжийн малын их зонхийг хонь эзлэнэ. Хонин сүргийн ихэнх нь хошууны зүүн хэсэг Баянтөгөл, Хужирын гол, Дундат, Залуу, Халиун, хошууны баруун хойд хэсэг Өрөм, Тогоо, Тал булгаар нутгалдаг сүрэгчдийн гарт байжээ. Хонин сүргээсээ их хэмжээний ноос авна. Нэлээд хэсгийг хятад, оросын пүүсүүдэд худалдаж, зохих хэсгийг эсгий хийхээр авч үлдэнэ. Хонины махыг богинын болон уртын идшинд хэрэглэнэ. Сүрэн гавьжийнх цөөхөн тооны тэмээтэй, их төлөв нүүж суухад ашиглана. Сүрэн гавьж хот айлыг 2-3 гэрээр мал малын захтай, сүргийн эргэлт хийх боломжтой, нүүж суухад бусдын гар харахгүйгээр зохион байгуулж байжээ. Энэ нь тухайн хот айл отор нүүдэл хийх, ноос үс авах, мал хээлтүүлэх, малаа хужирлах, хадлан авах, хашаа саравч барих өөрийн чадалтай байна гэсэн үг.

Сүрэн гавьж хээлтэгч малаас авах төлийн тоог зохистой тогтоож, илүү гарсан төлийг тухайн сүрэгчинд урамшил болгон өгдөг байсан гэнэ. Түүний малыг хариулах, эсэхийн тухайд гол болзол бол наад зах нь малаа өмнөх жилийнхээс хорогдуулахгүй байх явдал юм. Зуд турхан тохиолдоогүй үед малаа хоёр жил дараалан хорогдуулбал

малаа авч авч өөр хүнд шилжүүлэн өгч байсан гэнэ. Хонины ноосноос бусад малын ашиг шимийг авахдаа жил бүр хатуу тогтоосон журам баримталдаггүй, жилийнхээ наймаа арилжааны байдлаас харилцан адилгүй оногдол өгч байжээ. Зарим жил айл бүрээс цагаан идээ авахгүй тохиолдол ч байсан гэнэ. Гэсэн ч чөлөөлөгдсөн айлууд эзэндээ итгэл олох үүднээс сайн дураараа хөлдүү сүү, шар, цагаан тос, аарц, цагаа, ааруул, өрөм, шимийн архи шаардуулахгүйгээр бэлтгэж өгдөг байсан хэмээн хууччуул ярьж байна. Сүрэгчиддээ өвлийн идэш жил бүр өгөх бөгөөд бусад улиралд хэдэн хонь хүнсэнд хэрэглэх тоог тогтоож өгнө. Сүрэгчдийн хүүхэд өрх тусгаарлавал цөөн тооны мал тасдан өгч, итгэл үзүүлэн, үнэнч сүрэгчин өрхийн тоог нэгээр нэмнэ. Мөн жил бүр малаа нас хүйс, хөгшин залуу, зүс байдал, номхон, догшин занг ялгаруулан, тоо зүсээр бүртгэн тоолоод малаа өсгөсөн, уналга эдэлгээнд сайн сургасан өрхөд зохих тооны мал шагнал болгон өгдөг зэргээс зарц ядуучуудаас нэлээд олон өрх айл малжиж хөрөнгөжин дундчуудын эгнээнд орж байжээ.

Сүрэн гавьжийн аж ахуйн бас нэг гол чиглэл бол **газар тариалан** юм. Тэднийх Хужирын гол, Сэлэнгийн хойт тал Харлаг Тариахтай, Хөх хошуу, Тахилтай зэрэг газар улаан буудай, арвай, хар будаа тарина. Төмөр, анжис, борной, гар хадуур, хүрз зэрэг багаж зэвсгийг Хиагтын орос, Дайчин вангийн хошууны хил залгаа буриадуудаас худалдаж авч хэрэглэнэ. Дүү(будаа хэмжигч сав), тэвш, уур, нүдүүр, малтуур зэргийг өөрсдөө бэлтгэнэ. Тариа тарих, үр цацах, хурааж авахад хөгшин, залуу хөрвө нялхгүй татан оролцуулна. Бүгдийг хооллож, ундалж, зохих хөлс олгоно. Тариаг их төлөв гараар хадна. Тариа цайруулахад үхэр, мориор гишгүүлнэ. Сүрэн гавьжийн тариаланг эрхлэн, түүнийг бараадаж амьдардаг хэсэг айл байсан. Тэд тариа тарихаас эхлээд, тариа манах, ариглах, хураан авах, боловсруулах хүртэл бүх технологийн дамжлагыг хариуцна. Сайхь баян хааяа хятад тариачидтай хоршин тариа тарьж, тэдний туршлагыг судалж байв. Мөн ойр хавийн чадал мөхөс аж ахуйтанд зүтгэх хүчний мал, тарианы үр зээлдүүлэх замаар нэлээд хэмжээний үр тариа олж авдаг байжээ. Гол ажлыг нугалдаг тариачин өрхүүддээ жилийн идэшний арвай, хар будаа өгнө. Хар будааг боловсруулж шар будаа хийн, өрөмтэй хольж иднэ, арвайг үсэлж, гол төлөв хярамцаг хөшиглөн цагаатай арвай хэмээх хачин сайхан амттай хоол хийнэ. Мөн арвайгаар арвайн гурил бэлтгэнэ. Сүрэн гавьж тариачин айлууддаа зохих хэмжээний хар будаа, арвай өгч, боловсруулсан бүтээгдхүүн авдаг байжээ.

Хураасан тариагаа сайн, дунд, муу гэж гурав ангилан сайныг үрэнд хадгална. Тариачид үрийг нэн эрхэмлэх бөгөөд ийм ч учраас “үрээ идэхээр үхрээ ид” гэсэн үг гарчээ. Сайн болон дунд зэргийн будаагаар гурил хийнэ. Сүрэн гавьжийнх Бурхант, Эрээн Хайлааст, Харлаг, Тариат зэрэг газар морин ба усан тээрэмтэй. Тэдгээр нь тээрэмдэх, шигших, савлах зэрэг дамжлагатай, нэг ёсны жижиг үйлдвэр маягтай байжээ. Тээрмээр гурил үйлдвэрлэнэ. Бас бусдын тариаг хөлсөөр тээрэмдэнэ. Тээрэм бүрээс 100-200 жин тариаг хошууныхаа санд нийлүүлнэ. Хагарсан, хорчийсон, харласан будааг муу буюу хог будаа гэх бөгөөд тэдгээрийг малын тэжээлд өгөх юм уу, нутгийн ядууст хувааж өгнө.

Сүрэн гавьж намар ургацын баяр хийж, хүн амьтан хооллон, гурил будаа тараана. Мөн сайн тариачинг тодруулж урамшил шагнал өгнө. Бөх барилдуулж, морь уралдуулна. Лусад хүндэтгэл үзүүлж, Сэлэнгийн нэг цээлд 50 лангийн мөнгөн юмбүү, хадагтай өргөдөг байжээ.

Намар оройхон Сэлэнгэ мөрний мөс хадаалж байх үед Сүрэн гавьж тариагаа зааж авахаар гол гарахад мөс аяндаа шуугдан цэлмэдэг, Лусын эзэнтэй нөхөрлөж, ярьж, хэл амаа ойлголцдог ер бусын хүн байсан гэж нутгийн олон домоглон хэлэлцэж иржээ.

Сүрэн гавьжийн орлого олох нэг үүсвэр нь ердийн хөсгөөр жин тээвэрлэх явдал байв. Жинд явах бэлтгэлээ сайн базаана. Шар үхрээ зун жин тээх, өвөл жин тээх шар гэх мэтээр тарга хүчний байдлыг харгалзан бүлэглэнэ. Жишээ нь: өвөл жин тээх шарыг бүхэл зунжингаа шахаж тэжээнэ. Ийм үхэр өвс идүүлж, услаад явахад хүч нь тогтоод холын зам сайн туулах чадвартай болдог аж. Шар үхрийг өнгө зүс, эвэртэй, мухараар нь ижилсүүлэн зуу, зуугаар нь дүйцүүлэн жин тээнэ. Хүмүүс Сүрэн гавьжийн баян тарганыг дэврүүлэн ярихдаа “Түрүүчийн үхэр тэрэг нь Их Хүрээнд орж ирж байхад сүүлчийн үхэр тэрэг нь Вангийн хүрээнээс гарч байхаар олон шар тэрэг хөдөлгөдөг байсан” хэмээдэг. Түүний жин тээх үйл ажиллагааг 1) дотоодын, 2) хил хязгаарын гэж хоёр хувааж болно. Дотоодын жин тээвэр их, бага хэмээн ялгагдана. Дотоодын их жингээр өөрийн болон хятад, орос худалдаачдын бараа, түүхий эдийг зөөж, Нийслэл хүрээ, Хиагт, Хатгал руу хөдөлгөнө. Сүрэн гавьж жинчиддээ замын хүнс, тухайн улирлын хувцас, унах морь өгнө. Нэг жинчин дунджаар 15 үхэр тэрэг хөтөлнө. Жинг даамал ахална. Зөвхөн 1917 оны Хиагтын гаалийн бүрэн бус мэдээгээр үзэхэд, Сүрэн гавьж цагаан сарын 12-нд 167 үхэр тэрэг, 19 тэмээгээр, Х

сарын 15-нд 82 үхэр тэргээр, мөн сарын 21-нд 83 үхэр тэргээр, XI сарын 22-нд 60 үхэр тэргээр Вангийн хүрээнээс Хиагт хүртэл орос, хятадын худалдаачдын ноос, түүхий эдийг тээжээ. Эдгээр жингээс үзэхэд Сүрэн гавьжийн нэр дээр гааль хураасан боловч үнэндээ тэр өөрөө жин тээсэн бус, зөвхөн уг жинг тээхийг хэлэлцэн тохирч шар үхэр, тэргээ гаргаж бусад хүнийг хөлслөн жин тээлгэсэн хэрэг юм. (4.66)

Энэ үед бусдын юм тээвэл жин тээх үхэр тэрэг, мөн унах морь зэргийг гаргаад, хөлс мөнгийг нь жинхэнэ жин тээсэн хүмүүстэй тэнцүү хуваан авдаг байжээ. Үүнийг “шарын хүзүү хуваах” гэж нэрлэдэг аж. Сүрэн гавьж бас энэ аргаар орлого олж байжээ. Тэрбээр зөвхөн дээр дурьдсан хэдхэн удаагийн жингээс 138 рубль 04 мөнгөний гааль хураалгажээ. Үүнийг тэр үед олсон орлогын 5 хувьтай тэнцэх гааль хураалгадаг байснаар бодож үзвэл, 2760 гаруй рублийн орлого олсон гэсэн үг юм. Тэгвэл сайхь баян эдгээр жингээс “хүзүү хуваасных” гэж 1380 гаруй рублийн орлого олжээ. (4.66)

Жинчид буцахдаа хятад, оросын пүүсний бараа, мөн Сүрэн гавьжийн захиалгат цай, чихэр, боов, чавга, жимс, архи зэргийг ачиж хөдөлнө. Сүрэн гавьж бага жинг Ламын гэгээн, Заяын хүрээ, Хатгал руу хөдөлгөнө. Эргээд өөрийнхөө хэрэгцээний болон хятад, орос худалдаачдын барааг зөөж авчирна. Бага жинг бас Түшээт хан, Сайн ноён хан аймгийн тал хээр, говийн бүс рүү явуулна. Тэдгээр жинчид Сүрэн гавьжийн хувийн үйлдвэрлэлээр бэлтгэсэн гэрийн мод, төрөл бүрийн авдар, ор, чингэлэг, эмээлийн мод, уурганы мод, араг, савар, модон тэрэг, түүний тоноглол, агар хувин, торх, сүхний хусан иш зэрэг модон эдлэл, гар урлалын зүйл ачиж, тал хээр, говь нутгийнханд солилцох юм уу, худалдаад оронд нь хужир шүү, давс, хурганы арьс, элдсэн нэхий, ган болон мөнгөн сийлбэртэй хэт хутга, мөнгөн аяга зэргийг олж ирнэ. Гол ачаа нь хужир, шүү, давс байна. Хангай нутагт хужир мараа ховор учир олж ирсэн хужир шүү бол тэр чигээрээ мах, өөх тос, эрүүл мэнд гэсэн үг. Хангай нутагт хужрыг цайнд хийж уух буюу хужирссан малдаа өгч тарга хүч тогтооно. Шүүг арьс шир идээлэх, малд долоолгох зэргээр хэрэглэнэ. Сүрэн гавьж говиос авчирсан хужир шүүг өөрийнхөө малд өгөх буюу илүү гарсныг худалдана. Давсаа зарна. Сүрэн гавьж бас Чуулалт хаалга, Хөх хот, Долоннуур, Бээжин зэрэг хил давуулж жин тээвэр хөдөлгөдөг байжээ. Чингэхдээ их төлөв Ламын гэгээн буюу Эрдэнэ бандид хутагттай хоршиж байсан гэдэг. Жиндээ тэдний тэмээн хөсгийг голлон ашиглана. Өмнө зүг рүү бугын цусан болон ясан эвэр, хүдрийн заар, булга, үнэгний арьс, мөөг зэрэг ховор

нандин зүйл авч явна. Ер нь Дайчин вангийнхан Бээжин хүртэл жин хөдөлгөдөг, хэрхэн бэл бэнчинтэй байсныг харуулах нэгэн хууч яриаг энд өгүүлье.

Ар найман сумын Довдондорж хэмээх нэлээд баян чинээлэг хүн олон тэрэг ангийн үс ачиж, Бээжин хотыг зорих замдаа Вангийн хүрээнд буудаллажээ. Тэгэхдээ Сүрэн гавьжид бараалхаж, тамхилтал хөөргөний нь толгой салж унан хагарчээ. Гавьжтан “Ээ дамшиг” хэмээн халаглаад, орныхоо дээд талын шүүгээний нүдийг татахад их төлөв алтан нуух, оюу хавчаартай цэвэр шүрэн толгойтой, зааны ясан халбагатай том, жижиг олон янзын чамин эд байв.

Сүрэн:

- Эднээс аль тохирч таарсныг шилээд ав гэлээ. Довдондорж хөөрөгнийхөө толгойг хуучнаасаа илт дээрдүүлээд:

- Гавьжтан, Танд надад захиж, Бээжингээс авчруулах зүйл байна уу хэмээн асуулаа. Сүрэн:

- За юу ч байхав дээ. Манай жинчид Бээжингээс удахгүй ирнэ. Дараагийн жинчдээс чи түрүүнд ирэх учир гэрийн хөшиг хийх гэсэн хоргойноос ялихгүй дутаад байгаа юм гэж үзүүлээд:

- Та хэр хэмжээтэй дутаж байгааг өөрийн нүдээр харлаа, болбол олоод ирээрэй гэжээ.

Довдондорж ч Бээжинд очоод баяны захьсан хоргойг асууж сургалтал маш үнэтэй нандин эд байлаа. Үнэ хайрласангүй авч, Сүрэн гавьжид авчирч өгтөл:

- Ямар үнэтэй юм байна гэж асуув. Тэрээр нэрэлхэхдээ:

- Гайгүй шиг л авлаа гэжээ. Гавьжтан хойморын авдраа ухаж, нэлээд нандигнан хадгалсан нэг шаазан хөөрөг гаргаж өгөөд:

- Энэ маш чухал ховор эд юм шүү, битгий үрж зараарай. Өөрөө бариарай, юмтай хүн л барих хөөрөг гэжээ. Довдондорж баян дотроо “нэг муу шаазан хөөрөг. Нарийндаа хатсан баян байна даа. Хэрэггүй л их үнэ зарж хоргойг авчирлаа” хэмээн дотроо бодож байлаа.

Хожим Бээжинд очоод нэгэн пүүсийн эзэн өвгөжөөр данжаадтай нөгөө хөөргөөрөө тамхилахад эргүүлж тойруулж харснаа:

- Хай, хөөргөө надад зарчих гэлээ. Довдондорж “энэ баян хятад шохоорхож байхыг бодоход их үнэтэй эд гэдэг нь үнэн байх нь” гэж бодоод:

- Миний өвөг дээдсээс уламжилсан нандин хөөрөг байгаа юм. Би зармааргүй байна гэлээ. Хөгшин данжаад:

- Би эртний ховор нандин эдлэл цуглуулах дуртай хүн. Би үнэ хайрлахгүй авна гээд ханшаа хэллээ. Довдондорж тэр үнийг сонсоод арай л дуу алдсангүй. Сүрэн баянд аваачиж өгсөн нөгөө хоргойноос хэдэн арав дахин илүү үнэ хүрчээ. Наймаа тохиролцжээ. (5)

Сүрэн гавьжийнхан болон бусад газраас хоргой торго, шил шаазан, чулуун эдлэл, хөөрөг, гаансны соруул, мод, нанжин гахай гөлөм, суман ташуур зэрэг чамин зүйл, мөн өргөн хэрэглээний бараа авчирна.

Сүрэн гавьжийн үйл ажиллагааны бас нэг чиглэл бол **худалдаа наймаа** юм. Тэрбээр Орос, Хятад, Төвд худалдаачидтай холбоо тогтоож, мал, ноос, арьс, ангийн үс, бусад түүхий эдийн наймаа хийнэ. Ялангуяа орос худалдаачидтай үхрийн наймаа хийдэг байжээ. Түүнчлэн Нийслэл хүрээ, Хиагтад үхэр, хонь тууж, шар, цагаан тос, гурил будаа ачиж очиж наймаална.

Бас тэрбээр Дайчин вангийн хошууны Оростой хиллэдэг харуулын орчмын нутгийн орос, буриадуудад дүү самрыг дүү будаагаар наймаалж, мал болгох юмуу, эсвэл гурил болгон зарж байсан гэдэг. Сүрэн гавьж Вангийн хүрээнд суурьшин Бавгар Мишиг гэж алдаршсан орос худалдаачны пүүстэй хоршиж байсан гэж нутгийн хүмүүс ярьдаг. Хол, ойрын хүмүүс сайхь баянаас хүүтэй мөнгө зээлддэг байжээ. Тэрбээр гэрийн мод, тэрэг тоног, авдар сав, мал аж ахуйн тоног хэрэгсэл хийлгэх, сэлбүүлэх зорилгоор гар урчуудыг аж ахуйдаа авч ажиллуулж байжээ. Бас хөдөөгийн мужаан дархчуулын хийсэн бүтээгдхүүнийг цаашид илүү үнээр борлуулахыг бодолцон, боломжийн үнээр худалдаж авна. Вангийн хүрээний ядуучуудын хүчийг ашиглаж сур, арьс элдүүлэх, дээс томуулах, чөдөр ногт зангидуулах зэрэг ажил хийлгэнэ. Самар их ургасан жил Булган хан уул, Хантайн нуруу зэрэг газарт тусгай хүмүүс ажиллуулан, самар түүж, их хэмжээгээр цайруулж авна. Малчид, сүрэгчдийнхээ хүүхдүүдээр цагаан мөөг, гогод, хүмхээл, гоньд түүлгэж, хатаалгуулж авна. Ийнхүү Сүрэн гавьжид бодохгүй юм, хүрэхгүй салбар байгаагүй, хятадын пүүстэй өрсөлдөж байсан гэж нутгийн хүмүүс бахархан ярьдаг.

II. Бэл бэнчин, хүний мөс

Сүрэн гавьжийг гадарласан төдийгүй доторлосон хүрээ, хөдөөг хослон хөдөлдөг баян хүн байсан гэдэг. Тэднийх эдүгээгийн Булган хотын өмнө тал хуучин

Вангийн хүрээний Тамгын толгойн өвөрт (Хуучин тогтолцооны үеийн аймгийн Материал хангамжийн газар байсан) 10 орчим хашаатай нэгэн гудамжийг эзлэн суудаг байжээ. Тэр цагийн гэрч Вангийн хүрээнд шавилан сууж, баяны ажил үйлд туслан, гэдэс цадаж байсан өвгөн Жамбал : “Сүрэн гавьжийн хашаа гудамж одоогийн хангамжийн байгаа газар (Булган аймгийн хангамжийн газар байсан. Зох.) бөгөөд хашаандаа хувийн худагтай, өөр нэг хашаанд аян жингийн хүмүүс байрлах, буудаллах гэр, хоолны гэр гэж байх, тэр хавьд тусгайлан хашаанд үхэр тэрэг үй олноороо угсраатай байна. Зөвхөн буулганы (үхрийн) амбаар гэж тусгайлан байсныг бодоход их л хөлтэй баян байсан санагдана” (6) хэмээн ярьж байжээ. Өөрийн нь өргөө гудамжны дунд талд гурван том гэр, нэг гэр нь шүтээний өргөө, хоёр байшинтай, нэг байшингийн доор нь хоёр давхар зоорьтой тэнд алт, мөнгө эрдэнэсээ хадгалдаг байсан гэцгээдэг. Гудамжны бусад хашаанд олон агуулах байдаг, тэдгээр нь тус бүрдээ няравтай, будаа гурил, хүнсний зүйл, тэрэг тоног, сав суулга, хөдөлмөрийн багаж хэрэгсэл зэргээр эд юмсаа төрөлжүүлэн хадгалдаг байсан гэнэ. Тэдний гудамжны их зонхийг олон модон тэрэг угсран тавьсан том хашаа эзэлдэг. Зарим хүний ярьж байгаагаар 400-500 модон тэрэг, бусад тоног хэрэгсэл байсан гэнэ.

Ж.Болдбаатарын нагац өвөг Буджавын Ёндон гавьжийн дамжаа барихдаа Сүрэн гавьжаас мөнгө зээлдэхээр мөнгөний агуулахын зах зухыг үзсэнээ дурсан ярьж билээ. Агуулахад (зооринд) дөнгөж ормогц 50 лангийн мөнгөн ембүү хайрцагаа зад цохиод асгарсан байсан гэдэг. Ер нь мөнгөө хурган ембүү, хүйстэй ембүү, тойгон ембүү, чагтан ембүү, дугуй зоос (төгрөгөн) мөнгө, гулдмай, шүр, сувд гэх мэтээр төрөлжүүлэн жижиг, том хайрцаг буюу тулманд хийж хадгалдаг байсан гэнэ. Сүрэн гавьж хэр чансаатай зүйл эдлэж байсныг гэрчлэх нэгэн хууч яриаг өгүүлье.

Халхын толгой баяны нэг Ламын гэгээн Сүрэн гавьжийг хэр зэрэг нарийн нандин эд хогшилтой баян юм гэдгийг мэдэх гэсэн юм уу, эсвэл үнэхээр хэрэгцээ гарсан юм уу элч илгээж, “Бүтэн үхрийн мах багтах хаш чулуун тэвш байвал түр өгөөч” гэжээ. Тэд ламын гэгээний хүсэлтийг Сүрэн гавьжид айлтгахад олон юм ярьсангүй.

- Та нар замын алжаалаа тайлж, хэд хоног амар гэжээ. Тэд ч баянаар хэд хоног дайлуулж, алжаалаа тайлан зоо нуруу тэнийжээ. Нэг өдөр Сүрэн гавьж тэднийг дагуулан байшинд оруулан:

- Надад гурван хаш тэвш байна. Дунд хэрийн тэвш л Ламын гэгээний таалалд нийцэх болов уу гээд харуулахад цэнхэр, ягаан туяа цацруулж солонгорсон маш уран хийцтэй тэвш байж гэнэ. Тэрхүү тэвшийг хэдэн давхар эсгийгээр ороож, тэмээн тэргэнд ачиж аваачаад найр ёслолд хэрэглээд буцааж аваачиж өгсөн гэдэг. (5)

Сүрэн гавьж хошуу олондоо ээлтэй хүн болохыг нотлох баримт бол төрөлх нутгаа өөд татах талаар их зүйл хийж байжээ. Тухайлбал, тэрбээр хошууныхаа нэг жилийн албан татварыг ганцаараа төлөөд цаашид удаан хугацааны турш өөрөө татвараас чөлөөлөгдөх санал тавихад зарим түшмэд хаширлан сүүлдээ хошууны татвараа дийлэхгүй мунгинана гэж үзжээ. Чингээд жил бүр татвар авах нь ашигтай гэж тогтож байсан гэдэг. Гэхдээ зарим жил хошууныхаа татварыг төлөөд, ашиг хүү авч байсан ч гэж ярьдаг. Ямар ч байсан Дайчин вангийн хошуу аж ахуйн талаар хэцүүдэх үедээ Сүрэн гавьжаас хүч хөрөнгө авч тэнхэрч байсан аж. Тэгэхлээр Сүрэн гавьж Халхад хөрөнгө малаар хоёрт орж байсан том хошууны татварыг элбэгхэн даах чадалтай баян хүн байжээ.

Тэрбээр нутаг олныхоо сайн үйлсийг чадлын хэрээр дэмждэг, ивээн тэтгэгч хүн байжээ. Зарим жил Дайчин вангийн бөхийн сорилгын бүх зардлыг даана. Долоо хошуу даншиг, арван засгийн наадамд явах бөхчүүдийг гарахын өмнө заавал хооллодог уламжлалтай байсан гэнэ. Хүн бүрт нэг хөл мах чанаж, шөлөнд нь бантан хийж дайлаад, замын хүнсэнд нь нэмэр өгнө. Гурваас дээш давсан, цол нэмсэн бөхчүүдэд хурган ембүүнээс эхлээд 50 лангийн ембүү хүртэл шагнаж гар цайлгана.

Ардын засгийн газар 1923-1924 онд орон нутгийн засаг захиргааг ардчилсан үндсэн дээр зохион байгуулахдаа Богд хан уул аймгийн Булган хан уулын хошууны Баян төгөл сумыг (эдүгээгийн Булган аймгийн Бугат) Сүрэн гавьжийн сүрэгчдийн малыг үндэс болгожээ. Тус сум 1924 онд 150 өрхтэй, 2691 адуутай, 2691 үхэртэй, 15400 хоньтой, 1156 ямаатай байснаас зөвхөн Сүрэнгийн адуу 62.1 хувь, үхэр 62.6 хувь, хонь 77.8 хувь, ямаа 4 хувийг эзэлж байжээ. (7)

Сүрэн гавьж Дайчин вангийн хүрээнд байсан танхим (Бага сургууль)-д жил бүр өвлийн идэшний үеэр 30 хонь, 5 үхэр, 30 шуудай гурил будаа, аарц, цагаа, ааруул зэргийг хандвилдаг байжээ. Цагаан сараар хүүхэдэд дэвтэр харандаа, боов чихэр тараадаг байсан байна.

Сүрэн гавьжийн сайн танил нөхөр нь цагаан сарын боовны гурил элдэж өгөх зуураа:

- Та бурхны шавь хүн буяны мөрөөс хазайж бусдыг зарцлах нь номын ёсонд хазгай биш үү хэмээн тоглоом, шоглоом болгон хэлэхэд тэрбээр:

- Харин ч арга барсан амьтдын амыг хөдөлгөж яваагаа санваартан хүний сайн үйл гэж боддог шүү. Би нөгөө ертөнцөд очихдоо энэ олон мал хөрөнгийг тууж тээгээд явчихгүй олонд л үлдэнэ шүү дээ. Хойчис хожмынхондоо буян хишиг, хоол тэжээлтэй байлгах над мэтийн буян хийх хүн тэр болгон гарахгүй л болов уу хэмээн үнэн сэтгэлээсээ өгүүлж байжээ.

Сүрэн гавьж 1925 онд Дайчин вангийн хошуу засаг Жамбалдорж вангийн хэрэг гэгчид сэжиглэгдэж, 1920-30 онд тайж язгуур угсаатай хүмүүсийн хөрөнгө хураахад малын тоо, хөрөнгө хогшлоо нуун дарагдуулсан гэж баривчлагдан шийтгэгдээд удалгүй суллагдан гарчээ. Энэ үедээ хоёр ч удаа хөрөнгөө хураалгасан байна. Гурав дахь удаагаа 1937 оны IX сард Булганы хүрээн дээрээс ах дүү дөрвөн гавьж Сүрэн, Гунгаа, Гонсүрэн, Намжил нар хилс хэрэгт баригдан 1938 оны III сарын 11-нд цаазаар авахуулжээ. Тэднийг 1962 онд хилс хэрэгт цаазлагдсан гэж цагаатгасан байна. Түүний үеийн үед хуримтлуулсан мал сүрэг, баялаг хэдэн үеийнхнийг тэжээж, эдүгээ улбаалан яваа буй заа.

Abstract: P.Suren was a representative of the newly emerging bourgeoisie in Mongolia at the onset of the 20th century. He was a legendary figure, a wealthy man known for his managerial skills and human touch for others. His life was unfortunately abrupt during the Reign of Terror in 1938.

Ном зүй

1. Ц.Насанбалжир. Монголын аж ахуй хөтлөлтийн уламжлал, шинэтгэл. (XIX зууны эцэс XX зууны эхэн) УБ. 1978
2. Ш.Нацагдорж. Монголын феодализмын үндсэн замнал. УБ. 1978
3. МУУТА. Ф.А-16, хн-25
4. С.Идшинноров. XIX зууны эцэс XX зууны эхэн үеийн Монголын нэгэн баяны аж ахуйн дүр төрх. "Түүхийн судлал" XXI. УБ.1987
5. Булган нутгийн түүхч, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн Ц.Пүрэвсүрэнгийн цуглуулганаас
6. Д.Цэрмаа.Булган нутгийн баян Сүрэн гавьж "Дэвшилтэт" сонин 2000 оны XII сар
7. МУУТА. Ф-48, т-1. хн-6.